

**Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт**

1	Мэдэгдэл огноо	Он	2021	Сар	08	Өдөр	05
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	БОДЬ ДААТГАЛ ХК					
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	ДОТООД АЯЛЛЫН ДААТГАЛ					
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал					
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны	Шийдвэрийн нэр		Огноо		Дугаар	
		Даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд		2021.08.04		ТУЗ/21/13	
6	Цахимаар борлуулах эсэх	<input checked="" type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй					
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог		Нэр			
		Отгонхуяг		Нарангэрэл			
<b>Мэдээллийн төрлийг сонгоно уу.</b>							
8	<input checked="" type="checkbox"/> Даатгалын бүтээгдэхүүнийг шинээр борлуулах Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх						
<b>Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл</b>							
9	Даатгалын зүйл	Монгол улсын нутаг дэвсгэрт аялан явах үеийн аялагчийн бие эрхтний гэмтэл, амь нас, эрүүл мэнд					
	Даатгалын үндсэн эрсдэл	Гэнэтийн осол					
	Даатгалын нэмэлт эрсдэл	Нэр заасан өвчин					
	Даатгалын хураамжийн хувь,	Багцын сонголтын дагуу тооцно.					

**ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛ**

Даатгагч нь Даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д заасан үндэслэл үүссэн болон энэхүү даатгалын онцлогоос хамаарч дараах тохиолдлуудад аливаа үүрэг хариуцлага хүлээхгүй бөгөөд нөхөн төлбөр олгохоос татгалзана. Үүнд:

1. Урьд өмнө нь мэдэгдэж байсан архаг хууч өвчин, түүний үр дагавраас үүдэн гарсан хохирол болон гэрээний нэр томъёоны “Нэр заасан өвчин” гэсэн хэсэгт заасан өвчнөөс бусад тохиолдол түүний үр дагавраас учрах хохирол;
2. Даатгалын гэрээнд заагаагүй эрсдэлийн улмаас учирсан хохирол;
3. Даатгуулагчийн ажилтан согтууруулах, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн үед учирсан хохирол;
4. Санаатайгаар өөрийн биед учруулсан хохирол;
5. Мэргэжлийн спортын уралдаан тэмцээнд оролцох, усанд шумбах, бүхий л дотоод шаталтын хөдөлгүүртэй тээврийн хэрэгслээр уралдаан тэмцээнд оролцсон, уулын спорт, уул хаданд авирах, цас мөсний бүх төрлийн спорт агаарын спорт, шүхрээр буух, циркийн болон түүнтэй адилтгах

тоглолтонд оролцох, бүх төрлийн гүйлитийн уралдаан тэмцээнд оролцох зэргээс үүсэн гарах зардлууд;

6. Жирэмслэлт, төрөлт, дутуу төрөлт, зулбалт болон тэдгээрээс гарах хүндрэлүүд, түүний үр дагавар;
7. Бэлгийн замын бүх төрлийн өвчлөл, ДОХ/ХДХВ-ийн халдвартай холбогдон гарах зардал;
8. Ердийн өвчин болон архаг хууч өвчин, сэтгэл санааны гүн хямрал, цочрол болон сэтгэл мэдрэлийн өвчлөл, цус харвалт;
9. Мансууруулах бодис буюу спиртийн бүтээгдэхүүн хэрэглэх, түүний хор уршиг, амиа хорлох, өөрийгөө санаатайгаар бэртээснээс үүдэн гарах зардал;
10. Даатгуулахаас өмнөх нөхцөл байдал, ердийн өвчин, архаг хууч өвчин, сэтгэл санааны сааталт, мэдрэлийн өвчин, цус харвах, унах татах өвчин;
11. Даатгуулагч хууль бус үйл ажиллагаа болон гэмт хэрэг үйлдэхийг завдах эсвэл хийхтэй холбогдон гарах зардал;
12. Тухайн эмчилгээг стандартын дагуу бус, мэргэжлийн бус эсвэл эмчлэх эрхгүй эмчийн заавар зөвлөмжийн дагуу хийлгэсэн аливаа нэгэн зардал;
13. Хэвийн эрүүл шүдний эмчилгээ, хиймэл шүд, шүд авах, сонсгол шалгуулах, сонсголын аппарат тавиулах, чих цоолох, шивээс хийлгэх болон тэдгээрээс гарах зардал;
14. Нүдний үзлэг, хараа шалгуулах, ойрын болон холын харааг засах эмчилгээ, нүдний шил, линз, контактны линз тохируулах;
15. Согтууруулах ундаа, мансууруулах бодис болон эм хэтүүлэн хэрэглэсэн жолоодох эрхгүй хүнд жолоогоо дур мэдэн дамжуулсны улмаас даатгалын тохиолдол бүрдсэн;
16. Тусгайлсан захиалгат нислэг болон түүнтэй холбогдон гарах зардал;
17. Аялал жуулчлалын агентлаг, гэрээт ажилтан болон машин түрээсийн агент болон түүнтэй хамтран ажилладаг байгууллагын ажилтны алдаанаас холбогдон гарах зардал;
18. Даатгалын хугацаа дууссаны дараа цуцалсан түр зогсоосон тохиолдолд гарсан зардлууд;